



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 07 сарын 19 өдөр

Дугаар 60

Номгон

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын Соёрхол тэмдгээр шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн хурлын шагнал, түүнийг олгох журам”-ын 3.6 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Орон нутгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж буй Шинэжинст сумын иргэн Балжирын Нямхүү, Самдангийн Шингэд нарыг “Соёрхол” тэмдгээр шагнасугай.
2. Шагналд зарцуулагдах 100000 /нэг зуун мянган/ төгрөгийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шагнал урамшууллын зардлаас гаргахыг нягтлан бодогч /Г.Ариунбаяр/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

115373



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 07 сарын 19 өдөр

Дугаар 61

Номгон

“Чандмань-Баянхонгор” ХК-ний  
төлөөлөн удирдах зөвлөл  
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4 дэх заалт, Компанийн тухай хуулийн 62.1.7 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Чандмань-Баянхонгор” ХК-ний Төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай.

Ц.Төмөрбаатар-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч,  
Тэргүүлэгч

П.Рэнцэнпэлжээ-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч,  
Тэргүүлэгч

Н.Оюун- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, Тэргүүлэгч

Б.Энхтүвшин-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

Ц.Энхтөр- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, Тэргүүлэгч

М.Хосбаяр-Иргэний төлөөлөл

Д.Даваадорж-Иргэний төлөөлөл

2. Төлөөлөн удирдах зөвлөлд даалгах нь:

2.1 Компанийн дотоод журам, бүтэц орон тоо, цалингийн санг холбогдох хуулийн дагуу шинэчлэн баталж, компанийн эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэн, хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж ажилласугай.

2.2 “Чандмань-Баянхонгор” ХК-ний балансанд бүртгэлтэй урт хугацаат зээл, 2015 оны жилийн эцсээр 107,6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан шалтгааныг судалж холбогдох арга хэмжээ авсугай.

2.3 Компанийн одоогийн бүтэц зохион байгуулалт, өнөөгийн бодит байдлыг сайтар судлан хууль тогтоомжид нийцүүлэн өөрчлөх саналыг боловсруулж шийдвэрлүүлсүгэй.

3.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 49 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР





БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 07 сарын 19 өдөр

Дугаар 62

Номгон

“Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ний  
төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг  
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4 дэх заалт, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2012 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Баянхонгор -Эрчим хүч” ЦТХХК-ний дүрмийн 7 дугаар зүйлийн 7.4.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ний Төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн баталсугай.

Ж.Алтанцэцэг-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, Тэргүүлэгч  
М.Мөнхбат- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, Тэргүүлэгч  
Н.Баярсайхан- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, Тэргүүлэгч  
Б.Нацагдорж- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, Тэргүүлэгч  
С.Готов- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч  
С.Батцэрэн-Иргэний төлөөлөл  
Б.Батбаяр-Иргэний төлөөлөл

2. Компанийн дотоод журам, бүтэц орон тоо, цалингийн санг холбогдох хуулийн дагуу шинэчлэн баталж, компанийн эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэн, хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны 14 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

115377



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 07 сарын 19 өдөр

Дугаар 83

Номгон

Ээлжит хуралдааны тов зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 23 дугаар зүйлийн 23.4 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит II хуралдааныг 2016 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 10<sup>00</sup> цагт Баянхонгор сумын төвд зарлан хуралдуулж дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй.

1.1 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны дэгийг өөрчлөн батлах тухай

1.2 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх бодлогын хороодын бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах тухай

1.3 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын анхдугаар хуралдааны 1/5 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн дүгнэлтийг хэлэлцэх тухай

1.4 Аймгийн нийгэм, эдийн засгийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд өөрчлөлт оруулах тухай

1.5 Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах тухай

2. Хуралдааны бэлтгэлийг сайтар хангаж, асуудлыг Тэргүүлэгчдээр урьдчилан хэлэлцүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Д.Юндэнбазар/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

115371